

Олон улсын Театрын өдөр 2018 – Ази тив

Рам Гопал Бажаж, Энэтхэг улс

Театрын найруулагч, театр болон кино жүжигчин, академич, Дели дэх Драммын Үндэсний сургуулийн захирал асан

Хувьсан өөрчлөх түүх бүхэн бидэнд нэг л зүйлийг маш товч ойлгуулсан: амьд бүх юм мөнхөд үргэлжлэх хүртлээ хувьсан өөрчлөгдөж амь гарч байдаг. Хэрэв боломжтой байсан бол амь амьдрал цаг хугацаа, орон зайд нэвт шингэн үхэшгүй мөнх болох байсан биз. Хувьслын явцдаа амьдрал өөрийгөө зэрэмдэглэж бас нийтээр нь сүйрүүлдэг. Гэхдээ бид захгүй хөврөх бодол эрэгцүүлээ түр хязгаарлаж, чухамхүү чулуун зэвсгийн үеийн хүнээс сансрын эрин үеийн хүн болтлоо өөрчлөгдөн амьд үлдсэн тэрхүү чөлөөт хувьсал ба хүн төрөлхтний амьд үлдэх боломжийн тухайд хязгаарлая. Бид бусдад илүү санаа тавьж боддог болсон билүү? Илүү ухаалаг? Илүү баяр жаргалтай? Биднийг бүтээсэн байгаль дэлхийгээ илүү хайрладаг болсон уу?

Бид үүсэн бий болсон цагаас хойш амьд тайзны урлаг (бүжиг, дуу хөгжим, жүжиглэх/драм) байж, хөгжин өөрийн хэл буюу эгшиг, гийгүүлэгчээс бүрдэх цогц нэгдлийг бий болгосон. Эгшиг нь хүний сэтгэл хөдлөл, мэдрэмжийг үндсэнд нь илэрхийлдэг бол гийгүүлэгч нь хэлбэр болоод бодол, мэдлэгийг түгээх харилцаа юм. Математик, геометр, зэвсгийн эрдэм, одоо компьютер – энэ бүхэн үүний үр дүн. Тэгэхээр одоо бид хэлний энэ хувьслыг ухрааж буцаж чадахгүй болсон. Театрын амьд урлагийн баяр жаргал болоод мэдлэг (технологи ч хамаарна) үүнээс тархан гийгүүлж, хорвоогийн эрээн бараан8 уур хилэн, шунал болоод бүхий л муу муухайгаас салгахгүй юм бол энэ дэлхий цаашид оршин байх боломжгүй.

Олон нийтийн хэвлэл мэдээлэл болон шинжлэх ухаан, технологи биднийг яг л бурхад мэт хүчтэй болгосон. Тиймд, театр үнэндээ хямралд ороогүй харин түүний агуулга, илэрхийлэл болоод санаа нь хямарсан байна. Бид дэлхий хэмээх энэ гариг, угтаа бол театраа аврахын тулд өнөөгийн хүн төрөлхтөнд хандах хэрэгтэй. Бодитоор нь бид жүжигчний урлагийг, тайзны амьд урлагийг бага сургуулийн хүүхдүүдэд хүртээмжтэй болгох хэрэгтэй. Ингэсэн цагт залуу үе байгаль дэлхий болоод амьдралд илүү ухаалаг, шударга хандана гэдэгт би итгэлтэй байна. Хэлний давуу тал нь эх дэлхий болоод бусад гариг эрхэст илүү аюулгүй байх болно. Цаашилбал, амьдралыг тэтгэн авч үлдэхэд театр маш чухал байх болно. Тиймээс даяарчлагдаж буй энэ сансрын эрин үед тайзны амьд урлагийг бүтээгчид болон үзэгчид бие биедээ заналхийлэхгүйгээр хамтдаа нэг нэгнээ хөхиүлэн дэмжих хэрэгтэй.

Би театрыг магтан дуулж, хүн төрөлхтөнд үүнийг бүр багааас нь эхлүүлэн хот хөдөөгүй түгээн хөгжүүлэхийг уриалж байна. ‘Эд эрхтэн, хэл болоод энэрэл хайрыг хамтад боловсролоор дамжуулж залуу үед өвлүүлэн үлдээе.’

Орчуулсан Н. Болороо

